

Сарын мэдээний дүгнэлт

АНЭ-ийн хэмжээнд 2025 оны 02 сарын байдлаар 144 эх төрсөн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 42 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна.

Нийт амьд төрсөн 143 хүүхдийн 6 тохиолдол буюу /4.1%/ -нь 2500 граммаас доош жинтэй төрсөн байна. Нийт төрөлтийн 43.7%-нь жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэлтэй төрсөн ба нийт хүндрэлийн 58.7%-нь жирэмсэн үеийн хүндрэл байна.

Нас баралт

2025 оны 02 сарын байдлаар АНЭ-т нас баралтын 8 тохиолдол бүртгэгдсэн. Өмнөх оны мөн үеэс 2 тохиолдолоор өссөн байна.

Өвчний учир: Нийт – 7

1. Зүрхний архаг ишемит өвчин, тодорхойгүй (I25.9) – 1
2. Элэг ба элгэн дэх цөсний сувгийн өмөн (C22) - 1
3. Улаан хоолойн өмөн (C15) – 1
4. Бусад вирүст пневмони (J12.8) – 1
5. Бусад пневмони, үүсгэгч нь тодорхойгүй (J18.8) -1
6. Зүрхний хөндий ба дамжуулалтын төрөлх гажиг, тодорхойгүй (Q20.9) - 1
7. Нярайн амьсгал гачаалын хамшинж (P22.0) -1

Гадны шалтгаант -1

1. Гавал бяцрах (S07.1, шалтгаан Y04) – 1

Амбулатори, стационарын тусламж үйлчилгээ

АНЭ-т 02 сард стационарт 1649 үйлчлүүлэгч эмчлэгдэж гарсан ба ор хоног 11728 байна. Дундаж ор хоног 6.7 байна.

2024 оны 02 сард 177 мэс заслын хагалгаа хийгдсэний 10 тохиолдол нь эмэгтэйчүүдийн хагалгаа бүртгэгдсэн байна.

Нийт 22278 үзлэг хийгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1533-аар буурсан, 10.6% нь урьдчилан сэргийлэх үзлэг байсан ба 2.5%-иар өссөн, 26.8% нь идэвхтэй хяналтын үзлэг хийгдсэн ба өмнөх оны мөн үеэс 0.5%-иар өссөн байна. Амбулаториор 5935 өвчлөл бүртгэгдсэн байна.

Нийт түргэн тусламжийн 1037 дуудлага хүлээн авч гүйцэтгэсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 226 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна. Нийт дуудлагын 4.5% нь алсын дуудлага байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 5.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Эмгэг судлалын шинжилгээ 6 хийгдсэн. Эдийн шинжилгээ 106 тохиолдолд, эсийн шинжилгээ 915 тохиолдолд хийгдсэн.

Халдварт өвчин

АНЭ-т 2025 оны эхний 02 сарын байдлаар нийт 99 халдварт өвчин бүртгэгдсэн нь 10000 хүн амд 15%-тай байгаа ба өнгөрсөн оны мөн үеэс 5.2%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Халдварт өвчнийг бүтцээр нь авч үзвэл 45.4%-нь хурц халдварт өвчин, 12.1%-нь сүрьеэ 42.4%-нь БЗХӨ тус тус эзэлж байна.

Мэдээ хянасан: АНЭДарга:

Д.Алтантуяа

Мэдээ нэгтгэсэн: Статистикийн алба